БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2024/166/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2024 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: Б.Үүрийнтуяа<br>Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ..........
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..........
3. Санхүүгийн тайлангийн тодруулга..........
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..........
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин..........
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..........
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..........
4. Аудитын тайлан ..........
4.1 Ерөнхий зүйл ..........
4.2 Материаллаг байдал ..........
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..........
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..........
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..........
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..........
5. Аудитын илрүүлэлт ..........
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ..........

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2024.02.23 № 187
танай ___________-ны № ___________-т

САГСАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
А.ШЕПЕН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Тус газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд

00402269

хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **64,286,880.00** | **86,985,110.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | | |
| 31140 | Касс арилжааны банк | | |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **3121** | **Төгрөг** | - | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | - |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | | |
| **33** | **АВЛАГА** | 100,000.00 | 100,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 100,000.00 | 100,000.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | |
| **335** | **Бусад авлага** | - | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 36,925,880.00 | 46,885,110.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 36,925,880.00 | 46,885,110.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,444,600.00 | 382,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 35,481,280.00 | 39,702,860.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 6,799,750.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 27,261,000.00 | 40,000,000.00 |
| 36300 | Тэжээлийн нөөц | 27,261,000.00 | 40,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,091,701,343.86** | **4,349,789,190.19** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,091,701,343.86 | 4,349,789,190.19 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,430,665,343.86 | 3,687,448,554.43 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 638,981,017.00 | 937,238,217.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (63,781,454.85) | (80,360,029.94) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 183,114,793.00 | 166,124,793.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (98,819,202.49) | (99,139,161.17) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 90,220,540.00 | 108,976,540.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (36,830,250.79) | (52,273,977.67) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 54,523,659.04 | 54,523,659.04 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (15,466,274.63) | (21,213,088.18) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 1,932,419,298.00 | 1,932,419,298.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (64,910,160.38) | (110,957,210.76) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 900,447,817.41 | 1,005,058,840.41 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (121,064,437.45) | (152,949,325.30) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 31,830,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **393** | **Биет бус хөрөнгө** | **661,036,000.00** | **662,340,635.76** |
| 39301 | Програм хангамж | 2,013,400.00 | 3,436,639.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,013,400.00) | (2,132,003.24) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 661,036,000.00 | 661,036,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,155,988,223.86** | **4,436,774,300.19** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,696,809.00** | **4,666,290.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,696,809.00 | 4,666,290.00 |
| **413** | **Өглөг** | 5,696,809.00 | 4,666,290.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 2,036,689.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 5,696,809.00 | 2,629,601.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,150,291,414.86** | **4,432,108,010.19** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,120,116,878.07 | 1,120,116,878.07 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,120,116,878.07 | 1,120,116,878.07 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,120,116,878.07 | 1,120,116,878.07 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,631,259,074.21 | 1,913,075,669.54 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,631,259,074.21 | 1,631,259,074.21 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 281,816,595.33 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,398,915,462.58 | 1,398,915,462.58 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,155,988,223.86** | **4,436,774,300.19** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **810,933,505.21** | **1,169,930,007.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **193,032,705.21** | **304,837,462.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 193,032,705.21 | 304,837,462.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 189,699,135.21 | 278,647,462.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 3,333,570.00 | 26,190,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **617,900,800.00** | **865,092,545.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,475,700.00 | 41,188,645.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 15,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,475,700.00 | 25,688,645.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 612,425,100.00 | 823,903,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 581,575,100.00 | 823,903,900.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 30,850,000.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **709,077,790.18** | **888,113,411.67** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **709,077,790.18** | **888,113,411.67** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 590,819,687.18 | 816,595,644.67 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 267,723,100.00 | 428,206,856.00 |
| 210101 | Үндсэн цалин | 188,717,033.00 | 333,303,788.00 |
| 210102 | Нэмэгдэл | 43,064,152.00 | 83,076,068.00 |
| 210104 | Урамшуулал | - | 11,827,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 35,941,915.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,311,800.00 | 50,314,833.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,976,600.00 | 34,440,826.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,583,800.00 | 3,878,145.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,067,000.00 | 3,597,009.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 516,800.00 | 763,529.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,167,600.00 | 7,635,322.15 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,019,727.00 | 22,410,095.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,035,840.00 | 622,095.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,983,887.00 | 21,788,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35,103,508.00 | 39,976,077.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,226,200.00 | 4,904,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,205,058.00 | 32,528,592.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,629,250.00 | 1,370,935.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 43,000.00 | 1,172,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 303,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 303,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,218,520.00 | 582,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 27,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,218,520.00 | 555,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,714,000.00** | **2,300,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,714,000.00 | 2,300,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,991,600.00 | 5,851,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 721,000.00 | 5,790,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 542,200.00 | 28,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 228,400.00 | 33,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 232,434,432.18 | 266,954,383.67 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 99,647,753.00 | 130,379,168.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 220,000.00 | 445,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 132,566,679.18 | 136,129,615.67 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 118,258,103.00 | 71,517,767.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 30,850,000.00 | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 30,850,000.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,820,156.00 | 48,268,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,910,078.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 48,268,200.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 39,587,947.00 | 23,249,567.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,587,947.00 | 23,249,567.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | - |
| 220001 | Барилга байгууламж | - | - |
| 221001 | Их засвар | - | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **101,855,715.03** | **281,816,595.33** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | - | - |
| 145003 | Хөрөнгө оруулалтын олз | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | - |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө | - | - |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **101,855,715.03** | **281,816,595.33** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **617,900,800.00** | **865,092,545.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **617,900,800.00** | **865,092,545.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,475,700.00 | 41,188,645.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 15,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,475,700.00 | 25,688,645.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 612,425,100.00 | 823,903,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 581,575,100.00 | 823,903,900.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 30,850,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **567,621,075.00** | **749,522,545.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **567,621,075.00** | **749,522,545.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **473,273,050.00** | **678,004,778.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 267,823,100.00 | 423,542,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 186,330,600.00 | 297,741,672.00 |
| 210102 | Нэмэгдэл | 42,126,100.00 | 115,618,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | - | 10,181,928.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 39,366,400.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,311,800.00 | 52,942,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,976,600.00 | 36,001,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,583,800.00 | 4,235,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,067,000.00 | 3,388,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 516,800.00 | 847,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,167,600.00 | 8,470,800.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,719,727.00 | 22,913,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 735,840.00 | 1,125,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,983,887.00 | 21,788,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,272,650.00 | 39,107,210.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,118,800.00 | 2,840,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,102,300.00 | 34,239,875.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,985,850.00 | 1,613,935.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 65,700.00 | 413,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,301,000.00 | 423,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,301,000.00 | 423,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,487,500.00 | 2,821,795.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 650,795.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 71,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,487,500.00 | 2,100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,714,000.00 | 2,842,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,714,000.00 | 2,842,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,430,900.00 | 29,529,050.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 527,300.00 | 28,584,950.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 362,200.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 153,400.00 | 28,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 305,000.00 | 838,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 8,000.00 | 45,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **131,212,373.00** | **103,883,323.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 130,812,373.00 | 103,169,323.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 400,000.00 | 714,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **94,348,025.00** | **71,517,767.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 30,850,000.00 | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 30,850,000.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,910,078.00 | 48,268,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 23,910,078.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 48,268,200.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 39,587,947.00 | 23,249,567.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,587,947.00 | 23,249,567.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **50,279,725.00** | **115,570,000.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **-** | **-** |
| 140001 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| 140002 | Улсын төсвөөс олгосон зээл | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **50,279,800.00** | **115,570,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **50,279,800.00** | **115,570,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 50,279,800.00 | 115,570,000.00 |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 50,279,800.00 | 115,570,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(50,279,800.00)** | **(115,570,000.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 14 | **Бусад эх үүсвэр** | - | - |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | | |
| 145005 | Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (75.00) | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 75.00 | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,120,116,878.07 | 1,398,915,462.58 | 1,631,259,074.21 | 4,150,291,414.86 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,120,116,878.07** | **1,398,915,462.58** | **1,631,259,074.21** | 4,150,291,414.86 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | - |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,120,116,878.07** | **1,398,915,462.58** | **1,631,259,074.21** | 4,150,291,414.86 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,120,116,878.07** | **1,398,915,462.58** | **1,631,259,074.21** | 4,150,291,414.86 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,120,116,878.07** | **1,398,915,462.58** | **1,631,259,074.21** | 4,150,291,414.86 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 281,816,595.33 | 281,816,595.33 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,120,116,878.07** | **1,398,915,462.58** | **1,913,075,669.54** | 4,432,108,010.19 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 864,965,600.00 | 804,015,008.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 864,965,600.00 | 804,015,008.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 816,697,400.00 | 755,746,808.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 423,542,200.00 | 423,542,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 307,923,600.00 | 297,741,672.00 |
| 210102 | Нэмэгдэл | 115,618,600.00 | 115,618,600.00 |
| 210104 | Урамшуулал | | 10,181,928.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **52,942,800.00** | **52,942,800.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,001,100.00 | 36,001,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,235,400.00 | 4,235,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,388,400.00 | 3,388,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 847,100.00 | 847,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,470,800.00 | 8,470,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,913,000.00 | 22,913,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,125,000.00 | 1,125,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 21,788,000.00 | 21,788,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **38,705,200.00** | **37,971,505.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,840,000.00 | 2,840,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,058,200.00 | 33,104,170.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,480,000.00 | 1,613,935.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 327,000.00 | 413,400.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 430,000.00 | 423,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 430,000.00 | 423,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,170,000.00 | 2,821,795.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 999,000.00 | 650,795.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 71,000.00 | 71,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,100,000.00 | 2,100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,037,000.00 | 2,842,400.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,037,000.00 | 2,842,400.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 89,136,700.00 | 38,029,050.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 87,507,700.00 | 37,084,950.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 80,500.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 180,600.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 399,800.00 | 28,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 85,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 838,000.00 | 838,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 45,100.00 | 45,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 182,820,500.00 | 174,261,058.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 182,106,500.00 | 173,547,058.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 714,000.00 | 714,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **48,268,200.00** | **48,268,200.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 48,268,200.00 | 48,268,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 48,268,200.00 | 48,268,200.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | - |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 864,965,600.00 | 804,015,008.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 864,965,600.00 | 804,015,008.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 864,965,600.00 | 804,015,008.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26 | 27 |
| 620001 | Удирдах ажилтан | 9 | 9 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 9 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **26** | **27** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 9 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8 | 9 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 9 | 9 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **83,744,851.00** | **43,060,893.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **83,744,851.00** | **43,060,893.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 52,979,851.00 | 43,060,893.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 2,717,923.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 2,707,923.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 10,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 1,130,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 1,130,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 52,979,851.00 | 39,212,970.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 52,979,851.00 | 39,212,970.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **30,765,000.00** | **175,088.00** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 30,765,000.00 | 175,088.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | - |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 83,744,851.00 | 43,235,981.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 83,744,851.00 | 43,235,981.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 49,765,851.00 | 8,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,979,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 5,235,981.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь 2023 онд “Хөрөнгө оруулалтыг сумын хөгжилтэй уялдуулах замаар ард түмний санал санаачилгад тулгуурлан хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, аймгийн Загвар сум болгох” зорилго дэвшүүлжээ.

*Дээрх зорилтын хүрээнд доорх дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:*

I. Сумын нийгэм, эдийн засгийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын хүрэх түвшин тодорхойлох, иргэн бүр эрүүл, боловсролтой, орлоготой, амьжиргааны чадавхтай болгох.
II. Байгалийн баялаг, түүхий эдэд тулгуурлан хөгжлийг бий болгох
III. Ард иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжиж ажлын байр бий болгох

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар "Хөтөлбөр батлах тухай" тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус албанаас Сагсай сумын Засаг даргын тамгын газарт хяналт шалгалт хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн,* тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 280.1 сая төгрөгөөр буюу 6.8 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | - | - |
| Авлага | 100.00 | 100.00 | - |
| Урьдчилж гарсан зардал | | | - |
| Бараа материал | 36,925.88 | 46,885.11 | 9,959.23 |
| Нөөцийн бараа | 27,261.00 | 40,000.00 | 12,739.00 |
| Үндсэн хөрөнгө | 4,091,701.34 | 4,349,789.19 | 258,087.85 |
| **Нийт хөрөнгө** | **4,155,888.22** | **4,436,674.30** | **280,786.08** |
| Өр төлбөр | 5,696.81 | 4,666.29 | (1,030.52) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 4,150,291.41 | 4,432,108.01 | 281,816.60 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **4,155,988.22** | **4,436,774.30** | **280,786.08** |

*Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал дансуудад өөрчлөлт ороогүй, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын данс 22.6 сая төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн аж ахуйн материал болон нөөцийн өвс тэжээл хүлээн авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 258.1 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 115.6 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 278.6 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөнд 136.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өглөг дансны оны эхний өглөгөөс 3.1 сая төгрөгийг барагдуулж, оны эцэст шинээр 2.0 сая төгрөгийн ажиллагсадтай өглөг нэмэгдэж 4.7 сая төгрөгийн өглөгтэй гарсан.

Тайлант онд 281.8 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 281.8 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Орон нутгийн төсвөөс 625.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж орон нутгийн төсвөөс санхүүжих төсвийг 865.0 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс илүү батлагдсан нь 2023 онд цалин хөлс, орон нутгийн нэмэгдэл цалин нэмэгдсэнтэй холбоотой зардлыг тодотгож өгсөнтэй холбоотой илүү байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 865.0 сая сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 804.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, батлагдсан төсвөөс 20.0 сая төгрөгийг орон нутагт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 804.0 сая төгрөг буюу 93.0 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106** | | | | | |
| 1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 581,421.70 | 571,475.29 | 9,946.41 | 98.3 |
| 2 | 80102-Туслах үйл ажиллагааны зардал | 133,852.20 | 133,146.77 | 705.43 | 99.5 |
| 3 | 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж | 48,268.20 | 48,268.20 | 0.00 | 100.0 |
| 4 | 81102-Орон нутгийн нөөц хөрөнгө | 15,000.00 | 15,000.00 | 0.00 | 100.0 |
| 5 | 81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 86,423.50 | 36,124.75 | 50,298.75 | 41.8 |
| | **Дүн** | **864,965.60** | **804,015.01** | **60,950.59** | **93.0** |

*Эх сурвалж: Аудитын хийсэн ТГТайлан*

Үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрөөс 9.9 сая төгрөгийг, туслах үйл ажиллагааны хөтөлбөрөөс 0.7 сая төгрөгийг, байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрөөс 50.3 сая төгрөгийн нийтдээ 61.0 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй байгаа нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь нь дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 15.5 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 25.7 сая төгрөгийн нийтдээ 41.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, хангамж, бараа материалын зардалд 1.1 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 36.7 сая төгрөгийг хамруулан зарцуулж, оны эцэст 3.4 сая төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Засаг даргын тамгын газар нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

#### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сагсай сумын Засаг даргын тамгын газар нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 103.7 сая төгрөгийн бараа материал, 115.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03/12 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 685.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй боловч санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлагнал, санхүүгийн баримтыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул хөтөлбөр арга хэмжээний зардлууд болон төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтыг үзэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 217,746.6 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд 217,746.6 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 115,570.0 мянган төгрөгийн хөрөнгийг илүү, дутуу тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагын гүйцэтгэлийн батлагдсан төсвийг 41,094.1 мянган төгрөгөөр дутуу, гүйцэтгэлийг 61,077.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг тус тус залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1120.2 мянган төгрөгийн зөрчил илэрч акт тогтоосон.

### 5.1 Төлбөрийн акт

Тайлант онд 2022 оны орон нутгийн давсан хэсгээс 3 гэрээт ажилтан олгосон 22,275.0 мянган төгрөгийн цалингаас 1,680.3 мянган төгрөгийн цалингийн орлогын албан татварыг суутган

авснаас 1,120.2 мянган төгрөгийн татварыг төсөв төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж тайлагнаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 26 дугаар зүйлийн 26.1-д “*Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д "Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.3 “*бүх өр төлбөр*”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6-д “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ”, 26 дугаар зүйлийн 26.1.1-д *“ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос 10 хувиар тооцож албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”,* Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д *“бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй | 2 | 217,741.6 | | | 2 | 217,741.6 | 2 | 217,741.6 | | | | |
| **Дүн** | **2** | **217,741.6** | | | **2** | **217,741.6** | **2** | **217,741.6** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн | То о | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Цалингийн ашгийн татварыг төсөвт дутуу төвлөрүүлсэн. | 1 | 1,120.2 | 1 | 1,120.2 | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **1,120.2** | **1** | **1,120.2** | | | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |